

## **МОНГОЛ УЛСЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “МАСТЕР” ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг зүйл, үндсэн үзүүлэлт**

Хүн амын ахуйн үйлчилгээний мэргэжлийн онол, ур чадварыг олон улсын жишигт хүргэж, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, нэр төрөл, чанарыг сайжруулахад амжилт гаргаж, санаачлагатай ажилласан ахуйн үйлчилгээний салбарын үсчин, гоо засалч, оёдолчин, эсгүүрчин-зохион бүтээгч, гэрэл зурагчин, дархан, гутал засварчин, цаг засварчин, гэр ахуйн цахилгаан болон электрон хэрэгслийн засварчинг шалгаруулан ахуйн үйлчилгээний “Мастер” цол олгоход энэ журмын зорилго оршино.

Дараах нийтлэг шаардлагыг хангасан ажилтанг ахуйн үйлчилгээний “Мастер” цолд нэр дэвших эрхтэй.

Үүнд:

1. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;
2. Монгол улсын хууль, тогтоомжийн шаардлагыг бүрэн биелүүлж, хууль, хяналтын байгууллагаас торгууль, шийтгэл сүүлийн 5 жилд аваагүй байх;
3. Тухайн салбарын стандартын шаардлага хангасан ажлын байранд үйл ажиллагаа явуулдаг байх;

*Тайлбар 1: Үйл ажиллагаандаа шинэ техник, дэвшилтэт технологийг нэвтрүүлдэг байх, мэргэжлээрээ ажилтан сургасан байх нь нэмэлт шалгуур үзүүлэлт болно.*

*Тайлбар 2: Нэр дэвшигч нь онцгой өндөр амжилт үзүүлсэн тохиолдолд бусад шалгуур, үзүүлэлтийг хангаж байвал ажилласан жил харгалзахгүйгээр “Мастер” цол олгож болно.*

### **Хоёр. “Мастер үсчин”, “Мастер гоо засалч” цол олгох үзүүлэлт**

1. Гадаад, дотоодод зохион байгуулагдсан ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих, нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцож, амжилт үзүүлсэн байх.
2. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн ур чадварын улсын шалгалтад хамрагдаж, үсчин, гоо засалчийн 1-р зэрэг авсан буюу баталгаажуулсан байх;

### **Гурав. “Мастер оёдолчин”, “Мастер эсгүүрчин-зохион бүтээгч” цол олгох үзүүлэлт**

1. Өөрийн ур чадварыг харуулсан загвар зохион бүтээж, баталгаажуулсан байх.  
/Тайлбар: “Мастер эсгүүрчин-зохион бүтээгч” цолд нэр дэвшигчид хамаарна./
2. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих болон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцож, амжилт үзүүлсэн байх.
3. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн оёдолчин, эсгүүрчин-зохион бүтээгчийн 1-р зэрэгтэй байх;

### **Дөрөв. “Мастер гэрэл зурагчин” цол олгох үзүүлэлт**

1. Гадаад, дотоодод зохион байгуулагдсан ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих, нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцож, амжилт үзүүлсэн байх.
2. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн гаргаж, олон нийтэд танилцуулсан байх;
3. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн гэрэл зурагчны 1-р зэрэгтэй байх;

### **Тав. “Мастер дархан” цол олгох үзүүлэлт**

1. Өөрийн ур хийцийг шингээсэн загвар бүтээж, баталгаажуулсан байх.
2. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн гаргаж, олон нийтэд танилцуулсан байх.
3. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих болон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх.
4. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн дарханы 6-р зэрэгтэй байх.

### **Зургаа. “Мастер цаг засварчин” цол олгох үзүүлэлт**

1. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих болон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх.
2. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн цаг засварчны 4-өөс доошгүй зэрэгтэй байх.

### **Долоо. “Мастер засварчин” цол олгох үзүүлэлт**

1. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих болон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх.
2. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын болон техникийн мэргэжлийн мэдлэгтэй, мэргэжлийн засварчны 5-аас доошгүй зэрэгтэй байх.

### **Найм. “Мастер гутал засварчин” цол олгох үзүүлэлт**

1. Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, сургалт, аттестатчилал, үзүүлэх сургууль зэрэг мэргэжлийн ур чадвар сорих болон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх.
2. Өөрийн ур чадварыг харуулсан загвар зохион бүтээж, баталгаажуулсан байх.
3. Их, дээд болон мэргэжлийн сургууль төгссөн, онолын мэдлэгтэй, мэргэжлийн гутал засварчны 5-р зэрэгтэй байх.

### **Ес. Цол олгох журам**

1. Монгол улсын ахуйн үйлчилгээний үсчин, гоо засалч, эсгүүрчин-зохион бүтээгч, оёдолчин шалгаруулан “Мастер” цол олгох ажлыг сондгой тоотой жилд, гэрэл зурагчин, дархан, гутал засварчин, гэр ахуйн цахилгаан болон электрон хэрэгслийн засварчин, цаг засварчин шалгаруулан “Мастер” цол олгох ажлыг тэгш тоотой жилд тухайн жилийн III улиралд багтаан зохион байгуулна.

2. “Мастер” цолд нэр дэвшигчийг шалгаруулах зөвлөл (цаашид зөвлөл гэнэ) сонгон шалгаруулах товыг тогтоож, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
3. Аж ахуйн нэгж, байгууллага нь болзол хангасан нэр дэвшигчийн тодорхойлолтыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.
4. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Монголын Үйлдвэрлэлийн Хоршооллын Төв Холбоо (цаашид МҮХТХ гэнэ) буюу түүний орон нутаг дахь салбар холбоо болон холбогдох мэргэжлийн холбоотой хамтран хэлэлцэж, болзлын биелэлтийг хангасан гэж үзвэл цол олгуулахаар нэр дэвшүүлэх хүний холбогдох материалыг Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.
5. Монгол улсын ахуйн үйлчилгээний “Мастер” цолд нэр дэвшигч нь дараах бичиг баримт бүрдүүлнэ. Үүнд:
  - 5.1 Нийтлэг шаардлагын үзүүлэлт тус бүрийн биелэлтийг тодорхой гарган холбогдох бичиг баримтын хуулбарыг хавсаргасан байна.
  - 5.2 Тухайн нэр дэвшигчийг тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллагын тодорхойлолт;
  - 5.3 Хамт олны хурлаар хэлэлцсэн тухай протокол;
  - 5.4 Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үйлдвэрлэлийн Хоршооллын Төв Холбоо, салбар холбоо болон холбогдох мэргэжлийн холбооны санал, дүгнэлт;
  - 5.6 Нэр дэвшигчийн анкет, 2 хувь цээж зураг;
6. Зөвлөл нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг шаардлага хангасан гэж үзвэл онолын болон ур чадварын шалгалтад орох эрх олгоно.
7. Шалгалтын комиссын үнэлгээ нь зөвлөлийн шийдвэр гаргах үндэслэл болно.
8. Зөвлөлийн саналыг үндэслэн Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар ахуйн үйлчилгээний “Мастер” цол олгож, цол олгосон тухай гэрчилгээ, цолны тэмдэг, энгэрийн тэмдгийг гардуулж өгнө.
9. Шалгаруулалтад орохтой холбогдон гарах зардлыг нэр дэвшигч хариуцна.
10. Цолны тэмдэг, энгэрийн тэмдэг, гэрчилгээ хийлгүүлэх ажлыг МҮХТХ хариуцах бөгөөд холбогдох зардлыг “Мастер” цол эзэмшигчийг тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

### **Арав. Зөвлөлийн үйл ажиллагаа**

1. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 1.1 “Мастер” цол олгох, хүчингүй болгох талаар санал, дүгнэлт гаргах;
  - 1.2 Шалгаруулалтын тов тогтоож, явуулах;
  - 1.3 Шалгаруулалтын зардлын төсөв батлах;
  - 1.4 Нэр дэвшигчийн онолын болон ур чадварыг үнэлэх комиссын үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг батлах;
  - 1.5 Цолны тэмдэг, энгэрийн тэмдэгний загвар батлах;
  - 1.6 Аттестатчиллын журам баталж, явуулах;
  - 1.7 Бусад эрх, үүрэг;
2. “Мастер” цолтнуудын аттестатчиллыг 4 жил тутамд зохион байгуулна.
3. Аттестатчилалд хамрагдах шаардлагатай ажилтнуудын жагсаалтыг холбогдох мэргэжлийн холбоодын санал дүгнэлтийг үндэслэн гаргана.
4. Аттестатчилалд хамрагдахаас зайлсхийсэн, хүндэтгэх бус шалтгаанаар хамрагдаагүй болон шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол энэ нь тухайн “Мастер” цолтны цолыг хүчингүй болгох үндэслэл болно.
5. “Мастер” цолтон эмэгтэй 50, эрэгтэй 55 болон түүнээс дээш насанд хүрсэн бол аттестатчилалд хамрагдахгүй.

### **Арван нэг. “Мастер” цолтны эрх, үүрэг**

1. “Мастер” цолтон нь ажил үүргээ хариуцлагатай биелүүлж, “Мастер” цолны нэр хүндийг өндөрт өргөж ажиллана.
2. “Мастер” цолтон нь тухайн салбарын Тарифын хэлэлцээрийн дагуу өөрийн үйлчилгээний тарифыг тогтооно.

### **Арван хоёр. Цолыг хүчингүй болгох тухай**

1. Монгол Улсын ахуйн үйлчилгээний “Мастер” цолтон нь хэрэглэгчдийн эрх ашгийг хохироосон, үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн тохиолдолд хяналт, шалгалтын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн цолыг хүчингүй болгоно.
2. Аттестатчиллын шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол “Мастер” цолыг хүчингүй болгох үндэслэл болно.
3. Хүчингүй болсон цолны гэрчилгээ, тэмдэг, энгэрийн тэмдгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд эргүүлж хураалгана.

--- X ---